



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2023 оны 12 сарын 05 өдөр

Дугаар 17/68

Номгон

Г Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх /2023-2026 он/ арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай Г


Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17 дахь, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн Жендэрийн үндэсний хорооны 2022 оны 2 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө” (2022-2031 он)-г хэрэгжүүлэх зорилгоор аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.“Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх (2023-2026 он) арга хэмжээний төлөвлөгөө”-г хавсралтаар баталсугай.

2.Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг орон нутаг, холбогдох салбарын хэмжээнд нэгдсэн удирдлагаар хангаж, төсвийн зарцуулалт, үйл ажиллагааны хяналт шинжилгээг тогтмол, үнэлгээг 2 жил тутам хийж, биелэлтийн мэдээллийг жил бүр аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд танилцуулахыг аймгийн Засаг дарга (Д.Мөнхсайхан)-д даалгасугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Т.Норов)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Э.ЭНХБАТ

0121367

ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ САЛБАР
ДУНДЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
/2023-2026 ОН/ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Зорилго, зорилт, үйл ажиллагаа	Орон нутагт хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Зорилтот түвшин						Хэрэгжүүлэх байгууллага	
					2023	2024		2025		2026		Үндсэн	Хамтрагч
						Зорилтот түвшин	төсөв	Зорилтот түвшин	төсөв	Зорилтот түвшин	төсөв		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
1	Зорилго-1. Охид, хөвгүүд, эмэгтэй эрэгтэй хүмүүст эрүүл, аюулгүй амьдрах, сурч боловсрох тэгш боломж бүрдүүлнэ.	1.Боловсролын байгууллагуудад жендерийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлтийг хэрэгжүүлэх, жендерийн сургагч багш бэлтгэх	1.Сургууль, цэцэрлэгт жендерийн мэдрэмжтэй төрийн албаны шалгуурын хэрэгжилт 2.Бэлтгэгдсэн сургагч багш	хувь тоо	20 0	40 15	Орон нутаг	50 20	Орон нутаг	20 40	Орон нутаг	БШУГ	ЖСХ, ЕБС, СӨБ-ын байгууллагууд
1.1	Зорилт 1.1. Эрүүл идэвхтэй амьдрах тэгш боломж бүрдүүлж, эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүүг багасгана.	1.Сум, багаар дундаж наслалтын судалгаа гаргах, салбар дундын эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг хэвшүүлэх арга хэмжээ зохион байгуулах	Судалгаа төлөвлөлтөд тусгасан сум, дундаж наслалтын зөрүү	Тоо Зөрүү	2022 онд эрэгтэй 68.4 эмэгтэй 73.7 зөрүү	5 5.2	Орон нутаг	10 5.1	Орон нутаг	15 5	Орон нутаг	ЭМГ	БТСГ, сумдын ЗДТГ, Эрүүл мэндийн төв
1.1.1	Эрүүл мэндийн салбарын жендерийн бодлого, төлөвлөгөөг хэрэгжүүлэх, эрүүл идэвхтэй амьдралын мэдлэг, хандлага, дадлыг жендерийн мэдрэмжтэй хэвшүүлэх чадавх бүрдүүлнэ.	1.Сум, багт эрүүл мэндийн салбарын жендерийн /ажилтан/ мэргэжилтнүүдийг чадавхжуулах, мэргэшүүлэх, ажлын үр дүнг тооцох, бүрдүүлнэ.	Сум, багт бэлтгэсэн жендерийн мэргэжилтэн	тоо	0	31	Орон нутаг	21	БТ	21	БТ	ЭМГ ЖСХ	Сумдын ЭМТ, Өрхийн эрүүл мэндийн төв
1.1.2	Нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээ, дэд бүтцийг жендерийн мэдрэмжтэй хөгжүүлнэ.	1."Эрүүл мэндийн үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хүртээмжтэй байлгах ДЭМБ-ын аргачлал"-ыг нэвтрүүлэх	Аргачлалын хэрэгжилт	хувь	10	21	БТ	45	БТ	75	БТ	ЭМГ	НБХ, Сумдын ЭМТ Өрхийн эмнэлэг, Нэгдсэн эмнэлэг
1.1.3	Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн кабинетыг стандартын дагуу сум, орон нутагт байгуулж, хүний нөөцийг бэлтгэх, тоног төхөөрөмжөөр хангах	1.Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд, хөгжлийг дэмжих танхим байгуулах, тохижуулах, эрэгтэйчүүдийн эмнэлгийн тусламж үйлчилгээ, үзлэгт хамрагдалтын хувийг нэмэгдүүлэх	Байгуулсан кабинет/Үйлчлүүлэгчийн тоо	тоо/тоо	1/200	1/250	Орон нутаг БТ	1/300	Орон нутаг БТ	1/400	Орон нутаг БТ	ЭМГ	НБХ, сумдын ЗДТГ, Эрүүл мэндийн төв, Өрхийн эрүүл мэндийн төв
			Эрэгтэйчүүдийн хөгжлийн төв байгуулах	тоо/хувь	0/0	1/100	Орон нутаг БТ	3/300	Орон нутаг БТ	5/500	Орон нутаг БТ		
1.1.4	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхэд, тэднийг асран харгалзагчдын нийгмийн амьдралд оролцоход тулгарч байгаа саад бэрхшээлд жендерийн шинжилгээ хийж, салбар дундын төлөвлөлт хийж хэрэгжүүлэх	1.Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, асран хамгаалагчдын нийгмийн амьдралд оролцох тэгш боломжоор хангагдаж буй эсэхэд жендерийн шинжилгээ хийх 2.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгэм дэх тэгш оролцооны чанар хүртээмжийг нэмэгдүүлэх төлөвлөлтийг хэрэгжүүлэх	Зөвлөмжийн хэрэгжилт	хувь	0	50	Орон нутаг	55	Орон нутаг	60	Орон нутаг	ЖСХ	ЭМГ, БШУГ, БТСГ, ГБХЗХГ, бүх шатны Засаг дарга
			Төлөвлөгөөний хэрэгжилт	Хувь	0	50		70		100		ЖСХ	Бүх шатны ИТХ, Засаг дарга, НБХ, ХБИХолбоо ТББ

1.2	Зорилт1.2: Эрүүл идэвхтэй, жендерийн ялгаварлалгүй амьдралын хэв маягийг боловсрол, соёл, спортоор төлөвшүүлнэ.	1.Насан туршийн суралцахуйн төвийн сургалтын хөтөлбөрт Эрүүл идэвхтэй, жендерийн ялгаварлалгүй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх сургалтыг төлөвлөж, сургууль завсардсан цэргийн насны, ерх толгойлсон эмэгтэйчүүдийг чадавжуулах	Хамрагдсан иргэд	Тоо	0	1800	Орон нутаг БТ	2300	Орон нутаг БТ	2800	Орон нутаг БТ	БШУГ	ЭМГ, БТСГ, НТСТ
		2.Ахлах ангийн сурагчдын жендерийн эрх тэгш байдлын талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, эмэгтэй элсэгчдэд шинжлэх ухаан, технологи, инженерчлэл, математикийн чиглэлээр суралцах, мэргэжил эзэмшихийн давуу тал, ач холбогдлын талаар мэдээлэл танилцуулах	СТЕМ (Шинжлэх ухаан, технологи, инженерчлэл, математик)-ийн чиглэлээр суралцах эмэгтэй элсэгчид	хувь	30	45	Орон нутаг БТ	50	Орон нутаг БТ	60	Орон нутаг БТ	БШУГ	ЕБС, НТСТ
		3.Дотуур байранд амьдрахад нь дэмжлэг үзүүлэх орчин, үйлчилгээг бий болгох	Дэмжлэг үзүүлсэн сум, үйлчилгээний төрөл	тоо	3	2	Орон нутаг БТ	7	Орон нутаг БТ	9	Орон нутаг БТ	ЖСХ	БШУГ, сумдын ЗДТГ
		4.Увс аймгийн Бөхмөрөн сумын сайн туршлагыг нэвтрүүлэх	Нэвтрүүлсэн сум	тоо	0	1	Орон нутаг	2	Орон нутаг	3	Орон нутаг	ЖСХ	Сумдын ЗДТГ
		5.Уран бүтээлээр дамжуулан боловсрол олгох	Шинээр гаргасан уран бүтээл	тоо	0	2	БТ	3	БТ	4	БТ	СУГ	ЖСХороо
1.2.1	Бүх нийтийн эрүүл мэндийг хамгаалах, бие бялдрын хувьд эрүүл, илүүдэл жингүй байх хөдөлгөөн өрнүүлэхэд эрэгтэйчүүдийн байгууллагын оролцоог дэмжих	1."Эрүүл Монгол хүн" үндэсний хөдөлгөөний хүрээнд "Эрүүл иргэн-Хонгорын баялаг" арга хэмжээний төлөвлөгөөнд бүх нийтийн эрүүл мэндийг хамгаалах, бие бялдрын хувьд эрүүл, илүүдэл жингүй байх хөдөлгөөн өрнүүлэх арга хэмжээг тусган хэрэгжүүлэх	Төлөвлөгөөний хэрэгжилт	хувь	0	50	Орон нутаг	70	орон нутаг	90	орн нутаг	БТСГ	ЭМГ, ЖСХ, Эрэгтэйчүүдийн ТББ
		2."Зөв хооллолт- Хөдөлгөөн-Эрүүл бие" аяныг жил бүр эрэгтэйчүүдийг оролцуулан хэрэгжүүлэх	Аяны төлөвлөгөөний хэрэгжилт	хувь		30	БТ	50	БТ	90	БТ	БТСГ	ЭМГ, ЖСХ, Эрэгтэйчүүдийн ТББ
		3. Клубүүдийн үйл ажиллагааг дэмжих	Хамрагдагсад	тоо	50	80	Орон нутаг	120	Орон нутаг	150	Орон нутаг	БТСГ	ЭМГ, ЖСХ, Эрэгтэйчүүдийн клуб
1.2.2	Зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалтын арга зүйг хөгжүүлж, сум, багт жигд хүртээмжтэй зохион байгуулна.	1.Насан туршийн суралцахуйн төвөөр дамжуулан Оюуны дасгалжуулагчдын бэлтгэн зорилтот иргэдэд сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах	Зохион байгуулсан сургалт, арга хэмжээ	тоо	0	15	Орон нутаг	20	Орон нутаг	25	Орон нутаг	ХХУГ	НБХ ЭМГ, сумдын ЭМТ, ӨЭТ, ТББ
			Хамрагдсан иргэд, зохион байгуулсан сургалтын тоо	Тоо	176	29 дасгалжуулагч 600 хүнд сургалт		1500 хүн		2500 хүн			
1.2.3	Дотуур байранд амьдардаг бага ангийн хүүхдийг дэмжих туслах багш ажиллуулах эрх зүйн орчин бүрдүүлж, дотуур байранд амьдрахад нь дэмжлэг үзүүлэх орчин, үйлчилгээг бий болгох	1.Дотуур байрын багш нарыг жендерийн мэдлэг чадвараар мэргэшүүлэх, жендерт суурилсан орчин бүрдүүлэх	Орчин, үйлчилгээ бүрдсэн дотуур байр, мэргэшсэн хүний нөөц	хувь	40	60	Орон нутаг	80	Орон нутаг	90	Орон нутаг	БШУГ	АИТХ, сумдын ЗДТГ, ЕБС
1.2.4	Малчдын хүүхдэд СӨБ, бага боловсрол олгох орчныг жендерийн хувьд ээлтэй болгох, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх	1.Сумдад хэрэгжиж буй гэр цэцэрлэгийн үйл ажиллагааг өргөжүүлж, хүүхдүүдийн сургалт хүмүүжилд аавуудын үүрэг оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх	1.Сум тус бүрд хэрэгжүүлсэн арга хэмжээ	тоо	0	20	Орон нутаг БТ	25	Орон нутаг БТ	30	Орон нутаг БТ	БШУГ	Бүх шатны Засаг дарга, СӨБ
			2.Сайн туршлага нэвтрүүлсэн сум, цэцэрлэг	Тоо	910	850		800		650			

1.2.5	Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдыг хорт зуршил, болзошгүй эрсдэлт зан үйл болон жендерийн хэвшмэл ойлголтоос сэргийлэх үйл ажиллагааг эцэг эх, багш, суралцагчид (охид, хөвгүүд) –ын клуб, бүлгээр дамжуулан идэвхжүүлж дэмжинэ.	1.Мэргэжлийн байгууллага, сурагчдын өөрөө удирдах байгууллага, сайн дурын бүлгэм, клубийн үйл ажиллагааг дэмжин суралцагчдыг хорт зуршил, болзошгүй эрсдэлт зан үйл болон жендерийн хэвшмэл ойлголтоос сэргийлэх үйл ажиллагааг идэвхжүүлэх арга хэмжээг зохион байгуулах хүний нөөцийг бэлтгэх	ЕБС, СӨБ-ын байгууллагад бэлтгэсэн хүний нөөц	Тоо	0	5	Орон нутаг	10	БТ	15	БТ	ЖСХ	Бүх шатны Засаг дарга, БШУГ, ЕБС, СӨБ-ын байгууллага
1.2.6	Сургууль завсардсан охид, хөвгүүд, өрх толгойлсон залуу эмэгтэйчүүдийг дахин суралцуулах, мэргэжил олгоход дэмжлэг үзүүлэх	1.Сум, сургууль, багийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйчидтэй хамтран судалгаанд үндэслэн сургууль завсардсан охид, хөвгүүд, өрх толгойлсон залуу эмэгтэйчүүдийг ХААИС-ийн салбар сургууль, Политехник коллежид зуучлах, суралцуулах мэргэжил эзэмшүүлэх, ажлын байраар хангах	1.Ажлын байраар хангасан иргэдийн тоо	тоо	0	10	БТ	15	БТ	20	БТ	БШУГ	ХХҮГ, МСҮТ, ХААИС
			2.Дэмжлэгт хамрагдсан иргэн	Тоо	40	50		70		90			
1.2.7	Бүх шатны боловсролын сургалтын байгууллагад ажиллаж буй сэтгэл зүйчийг жендерийн чиглэлээр мэргэшүүлэх	1.ЕБС, СӨБ-ын сэтгэлзүйчдийн жендерийн талаарх мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх, чадавхжуулах	Мэргэшсэн сэтгэл зүйч	Тоо	10	15	БТ	20	БТ	25	БТ	ЖСХ	БШУГ, ЕБС, СӨБ-ын байгууллага
1.2.8	Олон нийтийн мэдээлэл, зар сурталчилгааны агуулгад хэвлэл мэдээллийн жендерийн мэдрэмжтэй байдлын шалгуур үзүүлэлтийг нэвтрүүлнэ.	1.Орон нутгийн хэвлэл мэдээлэл, цахим хэлбэрээр дамжуулан иргэд олон нийтэд жендерийн талаар мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулах түгээх	Мэдээллийн злэх хувь	хувь	2	10	Орон нутаг	12	Орон нутаг	15	Орон нутаг	СУГ	Орон нутгийн хэвлэл мэдээллийн алба, соёл, урлагийн байгууллагууд
1.3	Зорилт 1.3: Гэр бүл дэх тэгш харилцаа, хамтын үүрэг хариуцлагыг дэмжинэ.		1.Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэргийн бууралт	тоо	198	156	БТ	145	БТ	100	БТ	ГБХЗХГ	ЖСХ, ЦГ
1.3.1	Өрх, гэр бүлийн бүтэц, гэр бүлийн харилцаанд гарч буй өөрчлөлтийг үндэслэн гэр бүлийн харилцааны эрх зүйн орчныг сайжруулж, Гэр бүлийн тухай хуульд хамтран амьдрах хэлбэр, түүнтэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг тусгана.	1.Гэр бүлийн гишүүдийн эрх үүргийн талаар жендерийн тэгш эрхийн талаар хуулийн дагуу холбогдох мэдээ, мэдээлэл хүргэх сургалт зохион байгуулах	2.Сургалтад хамрагдсан хүн	тоо	0	1000	Орон нутаг	1500	Орон нутаг	2000	Орон нутаг	ГБХЗХГ	ЖСХ, БШУГ, ЦГ
1.3.2	Гэрлэлтийн гэрээний ач холбогдлыг сурталчлан таниулж, дэмжинэ.	1.гэрлэлтийн гэрээг олон нийтэд таниулах гэрээний хэрэгжилтийг сайжруулах	Гэрээний хэрэгжилт	хувь	0	100	БТ	100	БТ	100	БТ	ГБХЗХГ	
1.3.3	Эцэг эхийн үүрэг хариуцлага, ажил-гэр бүлийн үүргээ хослуулах, гэр бүлийн боловсрол, харилцааны талаарх мэдлэг, ойлголт олгох үйлчилгээг сум баг, хорооны түвшинд бий болгоно	1.Баянхонгор аймгийн зэвсэгт хүчний 339-р ангид "Сайн аав" зорилготой хөтөлбөр хэрэгжүүлэх	1.Хамрагдсан алба хаагч	тоо	0	200	Орон нутаг	250	Орон нутаг	300	Орон нутаг	ГБХЗХГ	Бүх шатны ИТХ, Засаг дарга
		2.Хамтарсан багийн сургалт, мэдээлэл сурталчилгааны ажил, арга хэмжээг эрчимжүүлэх	2.Хамрагдсан иргэд	тоо	27075	27315		27525		28000			
1.4	Зорилт 1.4. Хөдөөгийн охид, эмэгтэйчүүдийн амьдралын орчин, суурь нөхцөлийг сайжруулна.	1.Сум, багийн түвшинд охид эмэгтэйчүүдийн сургууль завсардалт, өрх толгойлсон байдал, хөдөлмөр эрхлэлт, хүчирхийлэлд өртөж буй байдал зэрэг суурь судалгаатай болох	Судалгаанд хамрагдсан иргэд	Хувь	0	30	Орон нутаг	40	Орон нутаг	60	Орон нутаг	ГБХЗХГ	Бүх яам

1.4.1	Аймгийн төвөөс алслагдмал амьдарч буй жирэмсэн эмэгтэйчүүдийн хяналтын явуулын тусламж, үйлчилгээг хөгжүүлж, эхийн амрах байртай болгож, сумандаа амаржих нөхцөлийг бүрдүүлнэ.	1.Амрах байр, сумандаа амаржих нөхцөлийг бүрдүүлэх	1.Тохижуулсан амрах байр, амаржих нөхцөлийг бүрдүүлсэн байдал	тоо	0	1	Орон нутаг	2	Орон нутаг	3	Орон нутаг	ЭМГ	Бүх шатны Засаг дарга, сумдын ЭМТ
		2.Алслагдсан сум багийн төвд иргэдэд үйлчлэх явуулын тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх,	2.Үйлчилгээний чанар	хувь	45	56		60		63			
1.4.2	Малчин эмэгтэй, эрэгтэйчүүдэд бэлгийн, нөхөн үржихүйн эрүүл мэнд, гэр бүл төлөвлөлт, хүчирхийлэлгүй харилцааны талаарх мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулах	1."Хүүхдэд ээлтэй орон нутаг" санаачилгын тогтвортой байдлыг хангах арга хэмжээний 2022-2025 оны төлөвлөгөөнд гэр бүлийн боловсрол олгох сурталтыг тусгах, хэрэгжүүлэх	1.Хамрагдсан иргэд	Тоо		30/1500	Орон нутаг	50/2500	Орон нутаг	70/3500	Орон нутаг	ГБХЗХГ	ЭМГ, Сумдын ЭМТ, БШУГ, ЖСХ
1.4.3	Байгаль орчинд ээлтэй аялал жуулчлал хөгжүүлэх чиглэлээр хөдөөгийн эмэгтэйчүүдийн чадавхыг бэхжүүлэх зөвлөх үйлчилгээ нэвтрүүлнэ.		2.Хамрагдсан эмэгтэйчүүд	Тоо	0	60		90		150		БОАЖГ	ХАБЭАСЗ
1.4.4	Улирлын шинжтэй ажил хөдөлмөр, гар аргаар ашигт малтмал олборлож байгаа иргэн, малчид болон нийгмийн эмзэг бүлгийн иргэдийг эрсдэлээс хамгаалах үйл ажиллагаанд ЖДШ хийж, төлөвлөгөө гарган хэрэгжүүлнэ	1.Улирлын шинжтэй ажил хөдөлмөр, гар аргаар ашигт малтмал олборлож байгаа иргэн, малчдын судалгаа гаргах, тэдний талаар авч хэрэгжүүлэх ажил, арга хэмжээг ХАБЭАСЗ-ын ажлын төлөвлөгөөнд тусгах	Судалгаанд хамрагдсан иргэд, төлөвлөгөөний хэрэгжилт	Тоо/хувь		50	Орон нутаг БТ	70	Орон нутаг БТ	90	Орон нутаг БТ	БОАЖГ	ХАБЭАСЗ
1.5	Зорилт 1.5. Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэхэд салбар дундын зохицуулалт, хамтын ажиллагааг эрчимжүүлнэ.	1.Салбар дундын арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах	Арга хэмжээний хэрэгжилт	ХУВЬ	0	50		60		80		ЖСХ	АИТХ, АЗДТГ
1.5.1	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хохирогчид тусламж, үйлчилгээ үзүүлэх салбар дундын хамтын ажиллагааг сайжруулсан Баянхонгор зэрэг аймгийн сайн туршлагыг судалж нэвтрүүлнэ.	1.Сум, багуудын хамтарсан багийн үйл ажиллагааг сайжруулах, шилдэг тэргүүний хамтарсан багийг шалгаруулах, туршлагыг түгээн дэлгэрүүлэх	Туршлага нэвтрүүлсэн хамтарсан баг	тоо	0	5	Орон нутаг БТ	10	Орон нутаг БТ	13	Орон нутаг БТ	ГБХХЗХГ	Бүх шатны ИТХ, Засаг дарга, НБХ, сум, багийн хамтарсан багууд
1.5.2	Жендерт суурилсан хүчирхийллийн хохирогчид үзүүлэх цогц үйлчилгээний туршлага, арга зүйг орон нутгийн удирдлага, ТББ-уудад нэвтрүүлж, чадавхжуулна.	1.Нэг цэгийн үйлчилгээний үйл ажиллагааг идэвхжүүлэх	Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэргийн бууралт	тоо	198	156	Орон нутаг БТ	145	Орон нутаг БТ	130	Орон нутаг БТ	ГБХХЗХГ	Бүх шатны ИТХ, Засаг дарга, ЦГ, ЖСХ
2	ЗОРИЛГО 2. Эдийн засгийн хүрээнд жендерийн тэгш боломж, тэгш оролцоог дэмжинэ.	1.Жендерийн зөрүүтэй байдлын үзүүлэлт: Эдийн засгийн оролцоо, боломж		Оноо		0.765		0.785		0.795		ХНХЯ	ЖҮХ
2.1	Зорилт 2.1: Хөдөлмөрийн зах зээл дэх нас, хүйсийн ялгаварлалыг бууруулна.	1.Орон нутгийн хөдөлмөрийн насны хөдөлмөр эрхэлж буй иргэдийн хүйсийн судалгааг сум, багаар гаргах	Нийт ажиллагчид, насны бүлэг, хүйсээр	хувь	0	50	Орон нутаг	65	Орон нутаг	85	Орон нутаг	ХХҮГ	СТХ

2.1.1	Орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, түүний хэрэгжилтэд жендерийн дүн шинжилгээ хийж, зөвлөмж гаргах	1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, түүний хэрэгжилтэд жендерийн дүн шинжилгээний зөвлөмжийг хэрэгжүүлэх	Төлөвлөгөө, хэрэгжилт	хувь	0	50	БТ	60	БТ	70	БТ	ХХҮГ	ЖСХ, БҮХК
2.1.2	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, үйл ажиллагааг жендерийн мэдрэмжтэй болгох	1.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хөдөлмөр эрхлэлтийн төсөл, хөтөлбөрийн санхүүжилтэд хамруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх	Ажлын байраар хангасан иргэдийн тоо	тоо	29	36	ХЭДС	41	ХЭДС	44	ХЭДС	ХХҮГ	ТББ, ЖСХ
2.3	Зорилт 2.3. Эдийн засгийн нөөц баялгийн хүртээмж, эрх мэдлийн хуваарилалтад жендерийн шударга байдлыг хангана.												
2.3.1	Бүх шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн жендерийн мэдрэмжтэй төсөвлөлтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх	1.Бүх шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийг жендерийн мэдрэмжтэй төсөвлөлтийн сургалтад хамруулах	Сургалтад хамрагдсан ИТХ-ын Төлөөлөгчид	Тоо	0	160	БТ	160	БТ	162	БТ	бүх шатны ИТХ	ЖСХ, ТББ
2.4	Зорилт 2.4. Цар тахлын сөрөг нөлөөг даван туулах бодлого, үйл ажиллагааг жендерийн агуулгаар хэрэгжүүлнэ.	1.Жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг төсөл хөтөлбөрийн хамрагдалтыг нэмэгдүүлэх, хүйсийн тэнцвэрт байдлыг хангах	Хамрагдсан иргэд	тоо	256	285	ЖДҮДС	305	ЖДҮДС	306	ЖДҮДС	ХХҮГ	ЖСХ, ХХААГ, БҮХК
2.4.1	Бичил, жижиг үйлдвэрлэл эрхлэгчдийг өртгийн сүлжээний кластерт нэгтгэж ажлын байр бий болгох төслүүдийг жендерийн мэдрэмжтэй хэрэгжүүлнэ	1.ЖДҮ дэмжих, Хоршоо дэмжих төслүүдийг жендерийн мэдрэмжтэйгээр хэрэгжүүлж, ажлын байрыг бий болгох	Хэрэгжүүлсэн төслүүд, бий болгосон ажлын байр	хувь	35	40		48		55		ХХААГ	ХХҮГ, БҮХК
3.2.1	Зорилт 3.2: Жендерийн эрх тэгш байдлыг хангах орон нутгийн тогтолцоог хөгжүүлнэ.	1.Орон нутагт хэрэгжүүлэх бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх	Гүйцэтгэл	Хувь	0	95		95		95		ЖСХ	Сум, агентлаг, байгууллагууд
3.2.2	Бодлого төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад хүйсээр ангилсан мэдээлэл, жендерийн статистик, жендерийн дүн шинжилгээний хүртээмж, ашиглалтыг сайжруулна.	1.Орон нутгийн төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, салбаруудад жендерийн статистик, судалгаа шинжилгээ, бусад мэдлэгийн бүтээгдэхүүний мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх	Мэдээллийн сангийн бүрдүүлэлт	хувь	25	45	Орон нутаг	58	Орон нутаг	65	Орон нутаг	ЖСХ, СХ	Төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, агентлаг
3.2.3	Төрийн байгууллагын захиргааны статистик мэдээллийг хүйсээр ангилж гаргах, ашиглах, дүн шинжилгээ хийх, үр дүнг хэрэглэгч, олон нийтэд хүргэх чадавх бүрдүүлнэ.	1.Төрийн байгууллагын захиргааны статистик мэдээллийг хүйсээр ангилж гаргах, ашиглах, дүн шинжилгээ хийх арга зүйд сургах, мэргэшүүлэх хүний нөөцийг бэлтгэх	Бэлтгэгдсэн хүний нөөц	тоо	0	Анхан шатны 20, дунд шатны 20,	Орон нутаг	Анхан шатны 50, Дунд шатны 10, шинжээч 2	Орон нутаг	Анхан шатны 50, дунд шатны шинжээч 3	Орон нутаг	ЖСХ, СХ	Сум, агентлаг, байгууллагууд
3.2.4	Жендерийн мэргэжилтэн, сургач баш, шинжээч, үндэсний шинжээчийг салбар, орон нутагт үе шаттайгаар бэлтгэнэ.	1.Сум, агентлаг, байгууллага, салбаруудад жендерийн мэргэжилтний орон тоо, цалинг шийдвэрлэх, хүний нөөцөөр хангах, жендерийн мэргэжилтэн бэлтгэх	Хүний нөөцийн хангалт	хувь	10	45	орон нутаг	55	орон нутаг	65	орон нутаг	ЖСХ	Сум, агентлаг, байгууллагууд
3.2.5	Бүх шатны байгууллагад жендерийн эрх тэгш байдлыг хангах арга хэмжээний төлөвлөгөө баталж хэрэгжүүлнэ.	1.Сум, агентлаг, байгууллага, салбаруудад жендерийн мэдрэмжтэй төлөвлөлтийг бий болгох, арга зүйд сургах	Төлөвлөгөө, хэрэгжилт	хувь	15	55	орон нутаг	75	орон нутаг	95	3.00	ЖСХ	Сум, агентлаг, байгууллагууд
3.3	Зорилт 3.3. Жендерийн мэдрэмжтэй төсөвлөлтийг бүх түвшинд нэвтрүүлнэ.	1.Орон нутаг, сум, байгууллагын төлөвлөлтөд жендерийн мэдрэмжтэй төсөвлөлтийг хэрэгжүүлэх, арга зүйг нэвтрүүлэх	Төрийн үйлчилгээний жендерийн тэгш байдлын үр нөлөө	хувь	25	45	орон нутаг	58	орон нутаг	62	орон нутаг	ЖСХ	Бүх шатны ИТХ, Засаг дарга

3.3.1	Төсвийн ерөнхийлөн захирагчдын ЖМТ-ийг хэрэгжүүлэх чадаахыг нэмэгдүүлнэ.	1.Төсөв захирагчдын жендерийн тухай ойлголт, жендерийн мэдрэмжтэй төсөвлөлтийн нэмэгдүүлэх, чадавхжуулах	Цахим болон танхимын сургалтад хамрагдсан удирдах ажилтан	тоо	8	100	БТ	50	БТ	41	БТ	ЖСХ	СТСХ, төсөв захирагчид
3.3.2	ЖМТ-ийн сайн туршлагыг салбар, орон нутаг, байгууллагын түвшинд тодорхойлж, түгээн дэлгэрүүлнэ.	1.Орон нутгийн бодлогын баримт бичиг, сум, агентлаг, байгууллагуудын төлөвлөлтөд жендерийн хандлагыг төлөвшүүлэх заалтыг тусгах, хэрэгжилтэд хяналт тавих	Бодлогын баримт бичиг, төлөвлөлтөд жендерийн талаар тусгасан заалтын эзлэх хувь	хувь	0.8	0.15	БТ	0.21	3.00	0.26	БТ	ЖСХ	Сум, агентлаг, байгууллага
3.4	Зорилт 3.4. Жендерийн эрх тэгш байдлыг хангах бүтэц тогтолцоог бэхжүүлж, хамтын ажиллагааг сайжруулна.	1.Засгийн газар, Төрийн албаны зөвлөлийн тогтоолыг хэрэгжүүлэх	1.Бодлогын баримт бичгийн хэрэгжилт	Хувь	65	70	БТ	75	БТ	80	БТ	ЖСХ	Бүх шатны Засаг дарга, агентлаг, байгууллагууд
3.4.1	Яам, агентлаг, аймаг, дүүрэг бүрийн бодлого төлөвлөлтийн нэгжид жендерийн орон тооны мэргэжилтэн ажиллуулна.		2 АЗДТГ-ийн жендерийн мэргэжилтний хангалт	Хувь	40	100	БТ	100	БТ	100	БТ	ЖСХ	АЗДТГ
4	ЗОРИЛГО 4. Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо, манлайллыг нэмэгдүүлнэ.		Жендерийн зөрүүтэй байдлын үзүүлэлт: Улс төрийн эрх мэдэл	Оноо		0.121		0.25		0.36		ЖСХ	
4.1	Зорилт 4.1. Улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцоо, манлайллыг нэмэгдүүлнэ.	1.Эмэгтэйчүүдийн улс төр дэх оролцооны мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах	Хамрагдсан эмэгтэйчүүд	хувь	10	25	Орон нутаг	35	Орон нутаг	45	Орон нутаг	АИТХ	Бүх шатны ИТХ, ТББ
4.1.1	Улс төрийн намын бодлого, үйл ажиллагаанд жендерийн тэгш байдлыг хангах үзэл баримтлал нэвтрүүлнэ.	1.АИТХ-д эмэгтэйчүүд гишүүдийн эзлэх хувийг нэмэгдүүлэх	АИТХ-д эмэгтэй гишүүдийн эзлэх хувь	Хувь	12.1	35	БТ	36.5	БТ	38	БТ	Улс төрийн намууд	Бүх шатны ИТХ
4.2.	Зорилт 4.2. Төрийн албан дахь жендерийн эрх тэгш байдлыг хангана.	ЖЭТБХТХуулийн хэрэгжилт		Хувь		30		60		80		ТАСЗ, ЖСХ	Бүх төрийн байгууллага
4.2.1	Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, төлөвлөлтөд хүйсийн 40:60 харьцааг хангах арга хэмжээг тусгаж хэрэгжүүлнэ.	1.Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, төлөвлөлтөд хүйсийн 40:60 харьцааг хангах	Харьцаа	хувь	27/73	30/70	БТ	32/68	БТ	34/66	БТ	ТАСЗ, ЖСХ	Бүх төрийн байгууллага
4.2.2	Төрийн байгууллагын дэргэдэх болон үндэсний хэмжээний хороо, зөвлөл, комисс зэрэг зөвлөлдөх буюу хамтын удирдлагын байгууллагын бүрэлдэхүүний хүйсийн харьцааг тогтоох, сонгон шалгаруулах, томилох нийтлэг зөвлөмж гаргаж, хэрэгжилтийг хангана.	1.Төрийн байгууллагуудын дэргэдэх зөвлөл, комисс, салбар, хороодын бүрэлдэхүүний хүйсийн тэнцвэрт байдлыг хангах	Хангалт	хувь	36/64	37/63	БТ	38/62	БТ	39/61	БТ	ТАСЗ, ЖСХ	Бүх төрийн байгууллага
5.1.	Зорилт 5.1. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох /харгалзан зохицуулах бодлого, түүний удирдлагыг жендерийн мэдрэмжтэй төлөвлөн хэрэгжүүлнэ.		Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой бодлого төлөвлөлтөд жендерийн тэгш байдлын үзэл баримтлал нэвтрэсэн эсэх			Үгүй		Тийм		Тийм		Хууль зүйн хэлтэс БОАЖГ	Бүх шатны ИТХ, Засаг дарга
5.1.1	Уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны доройтол ба жендерийн асуудлын харилцан уялдааг тодорхойлох судалгааг мал аж ахуй, уул уурхайн зэрэг салбарт хийж, зөвлөмж гаргаж хэрэгжүүлнэ.	1.Зөвлөмжийг хэрэгжүүлэх	Төлөвлөгөө, хэрэгжилт	хувь	0	85	Орон нутаг БТ	85	Орон нутаг БТ	85	Орон нутаг БТ	БОАЖГ	Бүх шатны ИТХ, Засаг дарга, агентлаг байгууллага,

5.2.	Зорилт 5.2. Байгаль орчныг хамгаалах, зохистой хэрэглээг төлөвшүүлэх, ногоон ажлын байрыг нэмэгдүүлэхэд жендерийн тэгш оролцоог хангана.	1.Сургалт, нөлөөллийн мэдлэгийн болон хэвлэл мэдээллийн бүтээгдэхүүнийг Жендерийн мэдрэмжтэй түгээх	Сургалт, нөлөөллийн бүтээгдэхүүн, торлоор	Тоо		1	Орон нутаг БТ	2	Орон нутаг БТ	3	Орон нутаг БТ	Соёлын хэлтэс ЖСХ	бүх шатны ИТХ, БОАЖГ
5.2.1	Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад чиглэсэн зохистой хэрэглээний дадлыг хэвшүүлэх сургалт, нөлөөллийн мэдлэгийн болон хэвлэл мэдээллийн бүтээгдэхүүнийг жендерийн мэдрэмжтэй гаргаж түгээнэ	1.Соёл, урлагийн байгууллагуудаас гаргаж байгаа уран бүтээлийг жендерийн мэдрэмжтэй түгээх	Шинээр гаргасан уран бүтээлийн тоо	Тоо	2	4	Орон нутаг БТ	6	Орон нутаг БТ	8	Орон нутаг БТ	СУГ,	СУБайгууллагууд
5.3.	Зорилт 5.3. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах чадавхыг эмэгтэй, эрэгтэй хүмүүс, нийгмийн бүлгүүдэд бүрдүүлнэ.	1 Мэргэжлийн байгууллага, ТББ-тай хамтран чадавхжуулах сургалт, зөвлөх үйлчилгээг зохион байгуулах	1.Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад оролцогчдын тоо, хүйсийн тэнцвэр байдал	Тийм/		Үгүй	Орон нутаг	Тийм	Орон нутаг	Тийм	Орон нутаг	БОАЖГ	ЖСХ
5.3.1	Байгаль орчинд эзлэй аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр эмэгтэйчүүдийн чадавхыг бэхжүүлэх зөвлөх үйлчилгээг нэвтрүүлнэ		2.Зохион байгуулсан сургалт, арга хэмжээ, хамрагдсан эмэгтэйчүүд	тоо		450		620		750		БОАЖГ	ЖСХ
5.3.2	Бүх шатны онцгой комиссын бүрэлдэхүүнд эмэгтэйчүүд, ахмад, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, залуучууд, аж ахуйн нэгж, ТББ-ын төлөөллийг оролцуулах замаар иргэдийн шийдвэр гаргах түвшний оролцоог нэмэгдүүлнэ	1.Иргэдийн шийдвэр гаргах түвшний оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх	Иргэдийн оролцоотой шийдвэр гаргасан акт, хэрэгжилтийн хувь	тоо/хувь	0	45	Орон нутаг БТ	65	Орон нутаг БТ	85	Орон нутаг БТ	ЖСХ	АИТХ

.....oOo.....

